



# СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

179 /179/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.11.15

## ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

### БЭЭЖИНГИЙН ЦЭРГИЙН АТТАШЕГИЙН КОРПУСЫН АЗИ, НОМХОН ДАЛАЙН ОРНУУДЫН АТТАШЕ НАРЫН ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-ны Батлан хамгаалахын атташегийн албанаас Бээжингийн цэргийн атташегийн корпусын Ази, Номхон далайн орнуудын атташе нарын ээлжит хурлыг зохион байгуулав. Хурлаар Батлан хамгаалахын атташе нар 2021 оны хамтын ажиллагааныхаа дүнг хэлэлцэж, 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний талаар санал солилцов. Тус хуралд Ази, Номхон далайн бүс нутгийн 34 орны Батлан хамгаалахын атташе оролцож, Элчин зөвлөх Л.Мөнхтүшиг мэндчилгээ дэвшүүлэн үг хэлэв.



Одоогийн байдлаар Монгол Улсаас гадаадын 9 улсад суугаа Элчин сайдын яаманд Батлан хамгаалахын атташегийн алба ажиллаж байгаа бол гадаадын 22 орны Батлан хамгаалахын атташе БНХАУ-ын Бээжин хот дахь ЭСЯ-даас манай орныг хавсран сууж батлан хамгаалахын хамтын ажиллагааг хөгжүүлж байна.

## Түүхэнд энэ өдөр

1923 он.

МАХЦ-ийн захиран командлах, улс хийгээд сургагч нар хийгээд улс төрийн бүрэлдэхүүний анхдугаар хурал нээгдэж, Ардын цэргийг байгуулах асуудал хэлэлцжээ.

## ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 3	☁️ -17

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 35	☁️ 23

## ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2,852.0	2,854.0
EUR 🇪🇺	3,270.0	3,290.0
CNY 🇨🇳	445.30	446.30
RUB 🇷🇺	40.40	40.90
JPY 🇯🇵	24.90	25.10
KRW 🇰🇷	2.39	2.40

## ЗУРХАЙ

2021.11.15 ДАВАА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 11/

ӨВЛИЙН ТЭРГҮҮН ШАРАГЧИН ГАХАЙ САРЫН ДӨРВӨН НОГООН УЛААГЧИН ТУУЛАЙ ӨДӨР

Үс засуулбал: Эрхтэн хурц болно.

НАРАН УРГАХ, ШИНГЭХ: 07.58-17.15

Барилдлага: Рашаан

Шүтэн барилдлага: Авахуй

Суудал: Хий

Хий

Хий

Хий

Ардын тооллын 11 сарын 15, Сумъяа гараг. Билгийн тооллын 11, Могойе хүлээч одтой, улаагчин туулай өдөр. Өдрийн наран 7 цаг 58 минутад мандан, 17 цаг 15 минутад жаргана. Тухайн өдөр хонь, гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд зөрөө сайн. Эл өдөр эм, эмнэлгийн элдэв үйл, хагалгаа хийлгэх, биеийн тамырыг сэргээх, мал аж ахуйн үйл, удирдлагын суудалд суух, хийморийн дарцаг хатгахад сайн. Газар хагалах, ус булгийн эм малтах, сэтгэлд сэтгэй газар очих, уул овоо тахирад муу. Өдрийн сайн цаг нь хулаана, бар, туулай, морь, хонь, тахиа болой.

Хол газар яваар одогсод урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эрхтэн хурц болно.

### “МОНБАТТ-11”-Т СОЁЛ ГЭГЭЭРЛИЙН ИЖ БҮРЭН ТЕКНИК ХЭРЭГСЭЛ ХҮЛЭЭЛГЭН ӨГЛӨӨ



БНӨСУ-д НҮБ-ын Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх Монгол Улсын Зэвсэгт хүчний 11 дүгээр ээлжийн Мотобуудлагын батальонд штабын болон холбогч офицерууд, штабын ахлагчаар үүрэг гүйцэтгэх албан хаагчдын зүгээс бие бүрэлдэхүүний сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, соёл хүмүүжлийн ажил, иргэн-цэргийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, дэмжлэг үзүүлэх зорилгоор соёл урлагийн иж бүрэн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгөх ажиллагаа

Жуба хотын дамжин өнгөрүүлэх баазад боллоо.

Уг арга хэмжээнд штабын офицеруудыг төлөөлж хурандаа Д.Жавхланбаяр үг хэлэхдээ “Цэргийн алба хаагчийн үүрэг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай зүйл бол сэтгэл зүйн хангалт, сэтгэл зүйн бэлтгэл болох бие бүрэлдэхүүний өдөр тутмын үйл ажиллагаа, цэргийн алба хаагчийн сэтгэл зүйг өргөх, тэмдэглэлт баяр, ёслолын арга хэмжээнд соёл гэгээрийн техник хэрэгсэл хамгийн чухал шаардлагатай байдаг” хэмээн онцоллоо. Мөн сайтар

бэлтгэгдсэн цэрэг үүргээ амжилттай гүйцэтгэнэ гээд бие бүрэлдэхүүнд амжилт хүсэж, цаашдын энхийг сахиулах ариун үүргээ нэр хүндтэй гүйцэтгэх ерөөлийг дэвшүүллээ.

Үүний дараа Мотобуудлагын батальоны захирагчийн орлогч, штабын дарга, дэд хурандаа Н.Гантөмөр хүчний штабт ажиллах офицер, ахлагч нарт хандаж, баярлаж, талархсанаа илэрхийлж, энхийг сахиулах ариун үйлсэд нь амжилт хүслээ.

Ахлах дэслэгч Ц.БАДАМСҮРЭН



### ЦДБЭЧ-ЫН 2021-2022 ОНЫ СУРГУУЛИЙН ЖИЛИЙН НЭЭЛТ БОЛЛОО

Ирэх онд түүхт 90 жилийнхээ ойгоо тэмдэглэх Монголын мэргэжлийн урлагийн анхдагч байгууллага Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулгын 2021-2021 оны сургуулийн жилийн нээлт боллоо.

Энэ жил Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн Хүндэтгэлийн тоглолт, Аугаа их эх орны дайны ялалтад зориулсан “Мөн ч залуухан байж дээ” кино концерт, “Эх орны дуудлага” гоцлол уран бүтээлчдийн тоглолт зэрэг томоохон тоглолт, уран бүтээлүүдийг үзэгч олноо толилуулсан тус чуулгын хамт олон ирэх сургуулийн жилд түүхт их ойгоо өргөн дэлгэр тэмдэглэхээс гадна “Эрдмийн” чуулгын өнгө төрхийг илэрхийлэхүйц судалгаа шинжилгээний ажилд анхаарлаа хандуулан ажиллах болно гэдгээ чуулгын дарга хурандаа Г.Золзаяа онцлон дурдав.

Дашрамд дурдахад, ЦДБЭЧ-ын Бүжиг алба үүсэн байгуулагдсаны түүхт 80 жилийн ойн арга хэмжээнүүд энэ өдрүүдэд үргэлжилж байгаа бөгөөд цэргийн бүжгийн үүсэл хөгжил, шилдэг уран бүтээл, цаашдын чиг хандлагын талаарх эрдэмтэн судлаачдын судалгаа шинжилгээний илтгэл хэлэлцүүлсэн Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж, бүжигчдийн уран бүтээлийн цахим контентуудыг бэлтгэн үзэгчдэд хүргэснээс гадна “Асаж дүүлсэн 80 жил” номоо уншигчдын гарт хүргэхэд бэлэн болгоод байна.



## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСЫН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 358,427 +666	ЭДГЭРСЭН 536,568	НАС БАРСАН 1,673 +9
----------------------------------	---------------------	------------------------

## ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 6332 +106	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 152	ЭДГЭРСЭН 6058
------------------------------	----------------------------	------------------

## КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 254,009,075
Эдгэрсэн Нийт: 229,661,001
Нас барсан Нийт: 5,114,949

Цахим шууданд

## БУЙЛС МОДНЫ 1000 ШИРХЭГ ҮР СУУЛГАЛАА



**Зэвсэгт хүчний 336 дугаар анги**  
ЗХЖШ-ын ахлагч, тэргүүн ахлагч Б.Гантөмөр болон "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний байгаль экологи хариуцсан мэргэжилтэн Н.Батболд нар ангид ажиллалаа. Тэднийг ангийн удирдлага угтан авах үеэр, хорооны ахлагч, тэргүүн ахлагч Б.Батхшиг ахлагчийн зөвлөлийн үйл ажиллагааг танилцуулсан юм. Мөн тэргүүн ахлагч Б.Гантөмөр ангийн ахлагч нарын бүрэлдэхүүнтэй уулзах үеэрээ Зэвсэгт хүчинд ахлагч нарын оролцоотой хийгдэж

байгаа ажил, арга хэмжээний талаар мэдээлэл өглөө.

Үүний дараа "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний аяны хүрээнд Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян тосгонд байгуулах мод үржүүлгийн газрыг сонгож, Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит цэцэрлэгт хүрээлэнд Буйлс модны 1000 ширхэг үрийг экологийн мэргэжилтэн Н.Батболдын заавраар ангийн бие бүрэлдэхүүн суулгалаа.

**Ахлах дэслэгч А.АЛТАНХУЯГ**

## АХМАД ҮЕ ТҮРШЛЭГАА ХУВААЛЦЛАА

**Зэвсэгт хүчний 014 дүгээр анги**

Хугацаат цэргийн алба хаагчид руу чиглэсэн соёл хүмүүжлийн ажил, арга хэмжээ төлөвлөгөөний дагуу амжилттай үргэлжилж байна. Бэлтгэл хурандаа С.Энхтайван "Цэргийн алба хаахын ач тус", "Монгол цэргийн бахархал" сэдвээр хугацаат цэргийн алба хаагчидтай чөлөөт ярилцлага хийж, алба хааж байсан үеийнхээ дурсамжийг хуваалцлаа. Тэрээр "Хувь хүн өөрөө өөрийнхөө сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах нь чухал юм. Цэргийн алба хаагчдын сэтгэл зүйн тогтвортой байдал нь ангийн хашаанаас бус хамгийн түрүүнд гэр бүлийн харилцаанаас эхэлнэ" гэж онцолсон юм. Мөн сургалтын төвийн офицер, ахлагч нарт "Цэргийн сэтгэл зүйн тогтвортой байдал", "Цэргийн алба хаагчидтай ажиллах арга барил"-ын талаар яриа, таниулга хийв. Уулзалтын төгсгөлд ангийн захирагч, хурандаа Г.Эрдэнэбаатар,



бэлтгэл хурандаа С.Энхтайванд сургалтын төвийн бие бүрэлдэхүүний өмнөөс болон хувиасаа баярласан талархсанаа илэрхийлж, амьдралд нь аз

жаргал, сайн сайхныг хүсэн ерөөж цаашдын ажил үйлст нь амжилт хүсэв.

**Дэслэгч Р.БИЛЭГ**

## АВЬЯАСЛАГ БАЙЛДАГЧИД ШАЛГАРАА



**Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл**

Нэгтгэлийн хугацаат цэргийн алба хаагчдын авьяас чадварыг нээн хөгжүүлэх, урлаг, гоо зүйн мэдрэмжийг дээшлүүлэх, тангаргийн баяраар тоглодох урлагийн тоглолтод оролцох бүрэлдэхүүнийг тодруулах зорилгоор урлагийн үзлэгийг зохион байгууллаа. Урлагийн үзлэгт нийт 9 салааны 120 гаруй хугацаат цэргийн алба хаагч оролцон дэслэгч Б.Батзаяа, дэслэгч И.Давааням, дэслэгч Э.Ням-Очир захирагчтай салаауд эхний 3 байрт шалгарсан бол шилдэг гоцлол дуучнаар байлдагч Т.Учрал, шилдэг язгуур урлагийн төрөлд байлдагч Б.Өнөболд, Ч.Хөвсгөлдэдий нарын үзүүлбэр шалгарлаа.

**Хошууч Д.ДОЛГОРЖАВ**

## "АРДЫН АЯЛГУУ" УРЛАГИЙН ИХ НААДАМД АМЖИЛТТАЙ ОРОЛЦЛОО

Завхан аймгийн Улиастай сумын УГЗ Л.Ванганы нэрэмжит Хөгжимт жүжгийн театрт баруун бүсийн "Ардын аялгуу" урлагийн их наадам зохион байгуулагдлаа. Тус урлагийн наадамд ангийн хөгжмийн салааны хөгжимчин Ц.Баасансүрэн "Язгуур урлаг", "Гоцлол хөгжим"-ийн төрөлд оролцож эхний үзүүлбэрээр шилдгийн шилдэг гранфрийн эзэн боллоо. Баруун бүсийн урлагийн их наадамд амжилттай оролцож анги байгууллагынхаа нэрийг өргөсөн хөгжимчин Ц.Баасансүрэнд захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга дэд хурандаа Д.Хишигбаатар жагсаалын өмнө баяр хүргэж сайшаалаа.



## "ЭХ ОРОНЧ ЗАЛУУ" ҮНДЭСНИЙ АЯНЫ ХҮРЭЭНД

**Зэвсэгт хүчний 032 дугаар анги**

Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулж буй цэрэг дайчдад эх оронч үзэл санааг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх, улс, үндэсний аюулгүй байдлыг хангах, тэдний соёл боловсрол, бие даан амьдрах чадвар, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг сурталчлах, хариуцлагатай иргэнийг төлөвшүүлэх зорилготой "ЭХ ОРОНЧ ЗАЛУУ" үндэсний аяны хүрээнд ангийн хугацаат цэргийн алба хаагчдад БЗД-ийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсээс "Эх оронч хүмүүжил, гэр бүл төлөвлөлт" сэдвээр сургалт явууллаа.

Мөн бэлтгэл хурандаа Э.Мөнхчулуун "Эх оронч үзэл", бэлтгэл хурандаа Ч.Баярсайхан "Үндэсний бахархал, Монгол хүн байхын учир" сэдвээр тус тус яриа таниулга хийлээ. Энэ үеэр ЦДБЭЧ-ын уран бүтээлчид ангийн байрлалд хүрэлцэн ирж, бие бүрэлдэхүүнд урлагийн тоглолтын дээжээс толилуулсан нь цэрэг эх оронч үзлийг бадраасан арга хэмжээ боллоо.

**Ахмад О.ГЭРЭЛЗАЯА**



**Зэвсэгт хүчний 303 дугаар анги**



Зэвсэгт хүчний Жанжин штаб, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, "Эрэг тэмүүлэл" НҮТББ хамтран "Залуучуудын хөгжлийг дэмжих" тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Залуучуудын байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулж буй "ЭХ ОРОНЧ ЗАЛУУ" аяны хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн Сургалт, судалгаа, мэдээллийн ахлах мэргэжилтэн Н.Мөнгөншагай, Хан-Уул дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн төвийн мэргэжилтэн Б.Бямбацэцэг нар Зэвсэгт хүчний 303 дугаар ангид ажиллалаа. Уулзалтын эхэнд тэд офицер, ахлагч, ажилтан албан хаагч нарт тус аяны зорилго, зорилтыг танилцуулж, сургалт зохион байгуулсан юм.

Тус аяны зорилго нь хойч үед, эх оронч үзэл санааг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх, эх орноо хайрлах, улс үндэсний аюулгүй байдлыг хангах тэдний соёл боловсрол, бие даан амьдрах чадвар, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг сурталчлах, хариуцлагатай иргэн байхад дэмжлэг үзүүлэх юм.

Сургалтын төгсгөлд Хан-Уул дүүргийн гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн төв Зэвсэгт хүчний 303 дугаар ангитай хамтран ажиллах, залуу офицер, ахлагч нарт чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлыг улам эрчимтэй зохион байгуулах, хамтын үйл ажиллагаагаа өргөсгөх зорилго тавилаа.

**СУРГАЛТ, СОЁЛ ХҮМҮҮЖЛИЙН АЛБА**

## "ЭХ ОРОНЧ ЗАЛУУ" ҮНДЭСНИЙ АЯНЫ ХҮРЭЭНД



Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас "Залуучуудын хөгжил"-ийн үндэсний хөтөлбөр болон "Өсвөр үе, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, "Эх оронч залуу" сургалт сурталчилгааны ажил төрийн цэргийн болон хууль сахиулах

байгууллагын алба хаагчдад цахим болон танхимгаар хүрсэн. Энэ ажлын хүрээнд Завхан аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга Г.Батдорж Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн нийт бие бүрэлдэхүүнд "Эх оронч залуу", "Зөв тэмүүлэл" гэсэн сэдвээр сургалт зохион байгуулж, хувь хүн бүр амьдрал ахуйдаа хэвшил болгох "Эх оронч байх 5 дадал"-ыг танилцуулав. Энэхүү сургалт нь хүн бүр зөв хандлагатай байснаар гэр бүл, хамт олон цаашлаад эх орноо хайрлахын утга учрыг бие бүрэлдэхүүнд хүргэж чадсанаараа онцлог байлаа.

## "ХӨГЖЛИЙН ГУРВАН ТУЛГУУР" СЭДЭВТ СУРГАЛТ ЯВАГДЛАА



Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр болон Өсвөр үе, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, "ЭХ ОРОНЧ ЗАЛУУ" үндэсний аяны хүрээнд Зэвсэгт хүчний 014 дүгээр анги,

Налайх дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн төв, "Гэр бүл, баяр хөөр" ТББ-тай хамтран гэр бүлийн бат бөх харилцааг бий болгох, залуучуудын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх зорилгоор ангийн офицер, ахлагч, ажилтан албан хаагчдад "Хөгжлийн гурван тулгуур" сэдэвт сургалтыг явууллаа. Энэхүү сургалтад ангийн бие бүрэлдэхүүн идэвх санаачилгатай оролцож, харилцан ярилцаж, хэлэлцүүлэг өрнүүлээ.



Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХУЯГ



ЦАХИМ ХАЯГ

Батлан хамгаалах яам  
Зэвсэгт хүчний Жанжин штаб



ЦАХИМ ХУУДАС

"Соёмбо" сонин  
"Дуулга" студи

\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.  
\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.  
\* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018

Цахим шууданд: Soyombo@mod.gov.mn  
Утас: 70001029, 3412 (дотуур)